- Мөн байгууллагуудын мэдээллийн технологийн тасралтгүй үйл ажиллагааг хангаж буй хэлбэрийг харахад Мэдээлэл технологийн дэд бүтцийн засвар үйлчилгээ /сервер, компьютер, принтер, сүлжээ/, тэдгээрийн хөгжүүлэлт, программ хангамжийн үйлчилгээ зэргийг гадны байгууллагаар, өөрсдийн үйл ажиллагааны цахим хуудас хөгжүүлэлт, завсар зэргийг дотооддоо, мэдээллийн технологийн архитектур хөгжүүлэлт зэргийг огт хийж гүйцэтгэдэггүй.



НИЙТ АЖИЛТНУУДАА МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН МЭДЛЭГ ОЛГОДОГГҮЙ

- Байгууллагуудын 67 хувь нь нийт ажилтнууддаа сургах, сургалтад хамруулдаггүй.




ЦАХИМ ШИЛЖИЛТИЙН ТӨСӨВ

- Байгууллагын ажилтнуудын
49 хувь нь компьютер ашигладаггүй
31 хувь нь үйл ажиллагаагаа явуулах албан ёсны цахим хуудасгүй
29 хувь нь дотоод сүлжээгүй
76 хувь нь нийлүүлэлтийн хэлхээний удирдлага /supply chain management/ байхгүй зэрэг үзүүлэлтээс дүгнэхэд байгууллагууд дунджаар жилийн төсвийн 11 хувийг цахимтай холбоотой технологид хөрөнгө оруулж байгаа нь хангалтгүй байна.


СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН МЭДЭЭЛЭЛ*

Судалгаанд оролцогчдын 38% нь эрэгтэйчүүд, 62% нь эмэгтэйчүүд оролцсон. Насны хувьд 26-35 насны бүлэг нийт оролцогчдын 25%-ийг, 36-45 насны бүлэг 22%-г бүрдүүлж байна. Ажил эрхлэлтийн хувьд цалинтай ажиллагч 43%, хувиараа хөдөлмөр эрхлэгч 19%-ийг эзэлж байна. Нийт судалгаанд оролцогчдын 40% нь дээд, 49% нь бүрэн дунд боловсролтой иргэд байна.

Хүйс:




Оршин суугаа дүүрэг:




Ажил эрхлэлт:

- Цалин хөлстэй ажиллагч
- Хувиараа хөдөлмөр эрхлэгч
- Өндөр настан
- Ажилгүй иргэн
- Оюутан/суралцагч
- Ажил олгогч
- Мал аж ахуй эрхлэгч
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн




Насны бүлэг:



Амьдардаг сууц:



Боловсрол:




Жич: Түүврийн тоо
N=330

*- сүүлийн 6 сарын хугацаанд төрийн үйлчилгээ авсан иргэд

А БҮЛЭГ- КОМПЬЮТЕРИЙН ХЭРЭГЛЭЭ


Судалгаанд оролцогчдоос хэрэглэж буй төхөөрөмжүүдийг тодруулахад 96% ухаалаг гар утас, 25% зөөврийн компьютер, 18% ажлын болон гэрийн суурин компьютерийг дурдсан ба компьютер ашигладаг оролцогчдын 55% нь өдөр тутамдаа ашигладаг байна. Мөн оролцогчдын хувьд ухаалаг гар утсыг яриа, дуудлага, мэдээлэл хүлээн авах, санхүүгийн буюу банкны үйлчилгээ авах, нийгмийн сүлжээний зориулалтаар түлхүү ашигладаг байна.



▪ Бараг өдөр бүр

▪ Шаардлага гарсан үед

▪ Ашигладаггүй



Яриа, дуудлага хийх, мессеж солилцох- **83.3%**

Мэдээ, мэдээлэл хүлээн авах-**74.5%**



Банкны үйлчилгээ авах- **70.3%**

Нийгмийн сүлжээг ашиглах- **68.2%**



Төрийн үйлчилгээ авах- **45.2%**

Хөгжим сонсох- **34.2%**



Цахим худалдаа хийх- **32.2%**

Ном унших- **21.2%**



В БҮЛЭГ- ИНТЕРНЕТИЙН ХЭРЭГЛЭЭ

18-25 насныхан нийгмийн сүлжээ ашиглах, ажил хайх болон анкет бөглөх, бараа үйлчилгээ худалдах/ худалдан авах онлайн сургалт, 26-35 нас болон 36-45 насны бүлгийнхэн и-мейл, Skype, Messenger, WhatsApp, Viber, сайтаар мэдээлэл хүлээн авах, төрийн үйлчилгээ авах, улс төрийн асуудлыг зөвлөлдөх, банкны үйлчилгээ авах зэрэг, 46-55 насны бүлгийн хувьд улс төрийн асуудлыг зөвлөлдөх, мэдээлэл хайх гэсэн зорилго хамгийн өндөр хувьтай хариулагдсан.

ХҮЛЭЭН АВЧ БҮЙ ХЭЛБЭР:


18-25

26-35


36-45

46-55

56-с дээш



ЗОРИЛГО:




Харилцаа холбоо
Мэдээллийн хүтээмж
Улс төрийн оролцоо
Бусад үйлчилгээ


С БҮЛЭГ- ЦАХИМ ЗАСАГЛАЛ, ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ

Судалгаанд оролцогчдын 76% нь цахим үйлчилгээг, 24% нь биечлэн үйлчилгээг илүүд үзэж байгаа ба насны бүлгийн хувьд 45 хүртэлх, боловсролын түвшний хувьд бүрэн дундаас дээш боловсролтой иргэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр авах хүсэлтэй байна. Цахим үйлчилгээ авч буй зорилгыг эрэмбэлэн харвал төрийн үйлчилгээний мэдээ, мэдээлэлтэй танилцах, албан бичиг татах болон илгээх зорилгууд хамгийн их давтамжтай хариулагдсан.

Насны бүлгээр:




Боловсролоор:



Цахим үйлчилгээний давуу тал

ЦАГ ЦАР ТАХЛЫН ҮЕД ЭРСДЭЛГҮЙ
ХЭМНЭХ
ҮЙЛЧЛҮҮЛЭХЭД ХЯЛБАР
ХҮНД СУРТАЛГҮЙ



ЦАГИЙН БОЛОН САНХҮҮГИЙН НӨӨЦ ХЭМНЭХ
Биечлэн очиход үйлчилгээний шат дамжлага, төлбөр зөвлөгөө бүрт цаг авах, дутуу материалаа бүрдүүлэхэд хамгийн багадаа 3-4 цаг зарцуулдаг. Харин цахимаар авахад 10 минут л болдог;

ХҮНД СУРТЛЫГ ХАЛАХ

Цахим үйлчилгээ хүнд суртал, танил талаараа дамжуулан бусдаас түрүүнд үйлчлүүлэх гэх мэт ёс суртахууны бус асуудлуудыг хална;

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЧААЛАЛ БУУРНА


Төрийн үйлчилгээ үзүүлж буй ажилтнуудын ачаалал болон цалингийн зардал, замын түгжрэлийг бууруулах эерэг дам нөлөөтэй;
/Иргэдийн ФБЯ-аас/

Цахимаар авч буй үйлчилгээ



ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ АВДАГГҮЙ ШАЛТГААН

Төрийн цахим үйлчилгээ авдаггүй гэж хариулсан 78 иргэдээс шалтгааныг тодруулахад **бүх насны бүлэгт** зонхилж байгаа хариултаар **хуулийн дагуу** эсвэл тухайн байгууллагын үйл ажиллагааны чиглэлээс хамаарсан иргэдийн мэдээллийн нууцлалтай үйлчилгээ авах, 18-25 наснаас бусад насны бүлэгт цахим үйлчилгээ авах ур чадвар, мэдлэг дутмаг, мөн судалгаанд оролцогчдын нас нэмэгдэх тусам биечлэн очихыг илүүд үзэх хандлага өсч байна.



БИЕЧЛЭН ҮЙЛЧЛҮҮЛЭХ ШААРДЛАГА

1. Хуулийн дагуу биечлэн очиж үйлчлүүлэх шаардлагатай: Газар зохион байгуулалтын алба, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газрын үйл ажиллагаа бүрэн цахимжаагүй.
2. Байгууллагын веб хуудсаар иргэд хангалттай мэдээлэл авч чадахгүй, лавлах ачаалал их.
3. Тухайн үйлчилгээг цахимжсан эсэх талаар мэдээлэл хомс.

/Иргэдийн ФБЯ-аас/



Насны бүлэг	Оролцогчдын тоо
18-25	9
26-35	10
36-45	18
46-55	20
56-с дээш	21
Нийт	78

ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮНДРЭЛ

“ 2021 оны 7 сард нэвтрэх хэсэгт гар утасны дугаар, тоон гарын үсэг, банкны эрхээр гэсэн сонголттой


- Гар утасны дугаараар орох гэхэд заавал өөрийнхөө нэр дээр байх гээд би нэвтэрч орж чадаагүй.
- Тоон гарын үсэг байхгүй тул алгассан.
- Банкны эрхээр нэвтрэх гэж байгаа боловч тэр нь ажилладаггүй. Нэвтрэх нэр, кодоо зөв хийгээд байхад буруу гэж гарч ирээд интернэт банкаа удаа блоклуулж байсан.



Цахим хэлбэрээр төрийн үйлчилгээ авсан иргэдэд тулгардаг нийтлэг хүндрэлийг тодруулахад

- 26-35, 36-45 настай болон бага боловсролтой иргэд тухайн үйлчилгээг цахимжсан эсэх талаар мэдээлэл дутмаг, вебсайт болон аппликейшний нэвтрэлт хүндрэлтэй
- 18-25, 36-45 настай болон бага сууриас дээш боловсролтой иргэд МАБ-д санаа зовдог гэж хариулсан байна.

Мөн 46-с дээш насны болон бага, суурь боловсролтой иргэд компьютер, гар утасны хэрэглээний мэдлэг дутмаг гэж хариулсан.



Цахим үйлчилгээний мэдлэг дутмаг, платформд нэвтрэхэд төвөгтэй, санаа зовдог, Мэдээллийн хамгаалалтад Компьютер, гар утасны мэдлэг дутмаг, Дата эрх аюух зардал их, тоон гарын үсэггүй Боловсролын түвшин

	Насны бүлэг					Төрийн үйлчилгээний хүндрэл	Боловсролын түвшин				
	18-25	26-35	36-45	46-55	56-с дээш		Бага	Суурь	Бүрэн дунд	Тусгай дунд	Дээд
40%	21%	36%	49%	43%	52%	Цахим үйлчилгээний талаарх мэдлэг, мэдээлэл хомс байдаг	100%	50%	44%	55%	29%
38%	27%	48%	47%	41%	26%	Төрийн үйлчилгээний системд нэвтрэхэд төвөгтэй	0%	25%	35%	45%	45%
32%	41%	30%	41%	28%	22%	МАБ-аа санаа зовдог	0%	50%	33%	32%	34%
23%	12%	9%	19%	33%	41%	Компьютер, гар утасны хэрэглээний мэдлэг, чадвар дутмаг	50%	50%	22%	35%	15%
19%	20%	16%	19%	21%	20%	Дата эрх авах, интернэтэд холбогдох зардал их	0%	0%	19%	19%	19%
19%	20%	16%	25%	17%	17%	Тоон гарын үсэг байдаггүй	0%	0%	20%	26%	17%
16%	18%	17%	14%	14%	17%	Төрийн үйлчилгээний төлбөрийг цахимаар төлөх боломжгүй	0%	0%	12%	23%	20%
10%	6%	7%	3%	10%	24%	Ухаалаг утас, компьютер зэрэг төхөөрөмжгүй	50%	25%	7%	23%	6%
9%	9%	6%	11%	7%	13%	Өөр хэн нэгэн миний өмнөөс үүнийг хийдэг тул бэрхшээлгүй	50%	0%	9%	6%	8%
3%	2%	1%	3%	9%	0%	Үйлчилгээний талаар нэмэлт лавлагаа авч чаддаггүй	0%	25%	4%	3%	1%
2%	3%	5%	1%	2%	0%	Интернет болон нэвтрэх төхөөрөмж, сүлжээ доголдолтой	0%	0%	2%	0%	4%
1%	0%	0%	1%	3%	0%	Цахим үйлчилгээ авах шаардлагагүй, авч байгаагүй	0%	25%	1%	0%	1%
1%	0%	0%	1%	2%	0%	Төрийн үйлчилгээ цахимаар үзүүлдэг автомат машинууд хангалтгүй	0%	25%	1%	0%	0%
8%	8%	5%	4%	5%	17%	Хүндрэлгүй	0%	0%	7%	10%	6%
1%	0%	0%	3%	2%	0%	Мэдэхгүй	0%	0%	1%	0%	2%



ЦАХИМЖУУЛАХАД АНХААРАХ ЗҮЙЛС

Судалгаанд оролцогчид цахим хэлбэрээр хувийн бичиг баримт, эрүүл мэнд, нийгмийн халамж тэтгэмжтэй холбоотой үйлчилгээг хамгийн түгээмэл авдаг ба цаашид цахим үйлчилгээнээс дараах хүлээлттэй байна.

1

ИРГЭДИЙН УР ЧАДВАР, МЭДЛЭГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

- ✓ Заавар, зөвлөгөөг хүртээмжтэй түгээх
- ✓ МАБ-н мэдлэгийг нэмэгдүүлэх

2

УЛАМЖЛАЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛБЭРИЙГ ХАЛАХ


- ✓ Үйлчилгээний цаг цахимаар авч, биечлэн очиж баталгаажуулах
- ✓ Цахим болон цаасан үйлчилгээг **нэг түвшинд** авч үзэх
- ✓ Төлбөрийн системийг цахимжуулах

3

БАЙГУУЛЛАГЫН БЭЛЭН БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

- ✓ **Ажилтнуудын** цахимтай холбоотой мэдлэг, ёс суртахууныг дээшлүүлэх
- ✓ **Харааны болон сонсголын бэрхшээлтэй** хүмүүст зориулсан тохиргоотой байх
- ✓ Санал, гомдлын шийдвэрлэлт, төлөв **нээлттэй** байх
- ✓ Аппликейшн/ цахим хуудасны санал, хүсэлтийг сонсож **сайжруулдаг** байх
- ✓ Банк/ бусад хувийн хэвшлийн байгууллагууд **хэрэглэгчийн мэдээллийг хамгаалах** зохицуулалттай байх
- ✓ **Нэгдсэн мэдээллийн сантай** болох

/Иргэдийн ФБЯ-аас/




Иргэд төрийн үйлчилгээ авахад шаардлагатай **интернет болон төхөөрөмжөөр хангагдсан** ч төрийн үйлчилгээг **цахимаар авч буй хувь** болон **цахимаар авахыг хүсч буй хувиуд** хоорондоо **урвуу** байна. Цахимаар үзүүлж буй төрийн үйлчилгээний төрөл **нэмэгдэж** байгаа ч иргэдийн **уламжлалт байдлаар үйлчилгээ авах хандлага өндөр хэвээр** байна.

2


удаа

Судалгаанд оролцогч 1 иргэн жилд дунджаар төрийн үйлчилгээ авах хэлбэр харгалзахгүйгээр авдаг



Иргэдийн төрийн үйлчилгээ авахад шаардлагатай интернет болон төхөөрөмжид хүндрэл учирдаггүй.

Төрийн үйлчилгээ авч буй хэлбэр



Иргэн болон ААН-ийн үйлчилгээний тоо N=218

Хамгийн сүүлд төрийн үйлчилгээ авсан хэлбэр



БИЕЧЛЭН

ЦАХИМ



- Зорилгоо биелүүлэхдээ 1.9 удаа очдог
- Хүлээлгэнд 29 минут
- Үйлчилгээ авахад 21 минут

Шалтгаан:

“Хуулийн дагуу биечлэн очиж үйлчлүүлэх шаардлагатай үйлчилгээ авах, биечлэн очихыг илүүд үзэх, цахимаар үйлчилгээ авахад төвөгтэй зэрэг шалтгаануудыг судалгаагаар хамгийн өндөр давтамжтай хариулагдсан.

Хүндрэл:

- Ажилтнуудын мэдлэг - Тоног төхөөрөмжтэй харьцах, тухайн үйлчилгээний мэдээллийг иргэдэд дутуу өгөх
- Хүнд суртал, танилдаа үйлчлэх
- Төлбөр - Төлбөр төлөх систем бүх түвшиндээ цахимжаагүй
- Сүлжээ сервер гацах
- Төр өөрт байгаа мэдээллийг дахин шаардах- цахим үйлчилгээний материалыг хүлээн зөвшөөрөхгүй байх
- Биометрик өгөгдлийг ашиглан үйлчилгээ авах боломжгүй”

Төрийн үйлчилгээ авахыг хүсч буй хэлбэр



ЦАХИМ

БИЕЧЛЭН



14 минутад үйлчилгээ авдаг

Шалтгаан:

1. “Цагийн болон санхүүгийн нөөц хэмнэх
2. Хүнд суртлыг халж төрийн үйлчилгээний иргэдэд хүрэх чанар, хүртээмж сайжрах
3. Төрийн үйлчилгээний болон замын хөдөлгөөний ачаалалд чухал нөлөөтэй


Хүндрэл:

- Бага боловсролтой болон 36-аас дээш насны иргэд “цахим үйлчилгээний талаар мэдээлэл, заавар зөвлөгөө хомс”
- Төрийн үйлчилгээний хамгийн том платформ болох E-Mongolia-д нэвтрэх үе шат төвөгтэй, банкны эрхээр нэвтрэх байгаа тул мэдээллийн аюулгүй байдалд санаа зовох
- 46-с дээш насны болон бага, суурь боловсролтой иргэд компьютер, гар утасны хэрэглээний мэдлэг дутмаг”


ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ БИЕЧЛЭН АВАХАД...

Иргэдээс төрийн үйлчилгээ авахад тулгардаг асуудлуудыг тодруулахад тоон судалгаагаар үйлчилгээний шат дамжлага олон, төр өөрт байгаа мэдээллийг шаардах хүндрэлүүд хамгийн олон давтамжтай хариулагдсан ба чанарын судалгаагаар мөн энэхүү 2 асуудал дурдагдсан. Мөн иргэдээс цахимжуулах хүсэлтэй төрийн үйлчилгээний үе шатуудыг тодруулахад анхан шатны бүрдүүлбэр бичиг баримт болон хуулийн хүрээнд биечлэн очих шаардлагагүй бүхий л үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх хүсэлтэй байна.

ХҮНДРЭЛ G1



ШИЙДЛИЙН САНАЛ



“ХУУЛЬ: Эдгээр байгууллагуудын үйл ажиллагааг цахимтай хослуулахад хуулийн хүрээнд хүндрэл гардаг.

АЖИЛТНУУДЫН МЭДЛЭГ: Тоног төхөөрөмжтэй харьцах, тухайн үйлчилгээний мэдээллийг иргэдэд дутуу өгөх

ХҮНД СУРТАЛ, ГАР ХАРАХ;

ТӨЛБӨР: Төлбөр төлөх систем бүх түвшиндээ цахимжаагүй

СҮЛЖЭЭ, СЕРВЕР гацах

ТӨР ӨӨРТ БАЙГАА МЭДЭЭЛЛИЙГ шаардах, цахим үйлчилгээний материалыг хүлээн зөвшөөрөхгүй байх

ХУРУУНЫ ХЭЭ-гээр үйлчилгээ авах боломжгүй, иргэний үнэмлэх шаардах”

/Иргэдийн ФБЯ-аас/

“ХУУЛЬ: Боломжит үйлчилгээг цахимжуулах зорилгын хүрээнд иргэдийг тоон гарын үсэгжүүлэх, хуулийн орчинг цахим шилжилттэй уялдуулан шинэчлэх

МЭДЭЭЛЭЛ: Цагийн хуваарь, ажилтнуудын мэдээлэл, бүрдүүлбэр материалын жагсаалтыг оруулах,

АЖИЛТНУУД-н тоног төхөөрөмж болон үйлчилгээний мэдлэг, ёс суртахууныг нэмэгдүүлэх

ТӨЛБӨР: Нэгдсэн төлбөрийн цахим системтэй болох

СҮЛЖЭЭ, СЕРВЕР: Нэгдсэн сүлжээний хүчин чадлыг сайжруулах, төрийн нэгдсэн мэдээллийн системтэй болох

ХУРУУНЫ ХЭЭ: Цахим үнэмлэхийг хурууны хээ бүрэн орлох боломжийг бүрдүүлэх”

/Иргэдийн ФБЯ-аас/

D БҮЛЭГ- ЦАХИМТАЙ ХОЛБООТОЙ УР ЧАДВАР БОЛОН МЭДЛЭГ

Иргэдийн цахим үйлчилгээ авахтай холбоотой эзэмшвэл зохих ур чадварын түвшинг тодруулахад мессенжер, и-мейл, оффисын хэрэглээний анхан шатны ур чадварийг 50%, дунд шатны буюу программ хайх, файл дамжуулах гэх мэт чадварыг 30%, мэдээллийн аюулгүй байдал, нууцлал, програмчлал зэрэг чадварыг иргэдийн 19% нь эзэмшсэн байна.

Ур чадварын түвшин	Бүлгийн дундаж	Ур чадварын дундаж	Насны бүлэг					Ур чадвар	Боловсролын түвшин				
			18-25	26-35	36-45	46-55	56-с дээш		Бага	Суурь	Бүрэн дунд	Тусгай дунд	Дээд
Анхан	47%	56%	67%	61%	59%	50%	46%	Цахим мессеж илгээх, авах	0%	25%	59%	42%	62%
		49%	71%	61%	55%	36%	22%	Бичиг баримт хавсарган и-мэйл илгээх	0%	25%	45%	32%	66%
		45%	65%	62%	47%	34%	17%	Microsoft Word-ийн анхан шатны ур чадвар	50%	50%	33%	26%	72%
		44%	77%	63%	44%	24%	11%	Microsoft Power Point -ийн анхан шатны ур чадвар	0%	25%	35%	23%	71%
		41%	64%	62%	41%	26%	13%	Microsoft Excel -ийн анхан шатны ур чадвар	50%	25%	29%	23%	69%
Дунд	28%	37%	56%	52%	40%	26%	13%	Интернэтээс программ хайх, татаж авах, суулгах	0%	25%	33%	23%	54%
		37%	59%	47%	42%	24%	13%	Файл дамжуулах (камер, гар утас, хөгжим тоглуулагч зэргээс)	0%	0%	30%	26%	57%
		16%	32%	21%	12%	10%	4%	Программ хангамжийн программын тохиргоог өөрчлөх эсвэл шалгах	0%	0%	10%	6%	28%
		21%	39%	29%	21%	7%	9%	Интернэт хөтчийн аюулгүй байдлын тохиргоог өөрчлөх	0%	0%	15%	6%	36%
Ахисан	18%	26%	45%	39%	29%	12%	4%	Microsoft Excel -ийн ахисан түвшний ур чадвар	0%	0%	17%	10%	48%
		19%	32%	28%	16%	16%	4%	Үйлдлийн системийг суулгах эсвэл солих	0%	25%	13%	10%	33%
		16%	29%	18%	18%	10%	2%	Веб хуудас үүсгэх	0%	0%	13%	10%	24%
		10%	24%	14%	12%	0%	0%	Тусгай программын хэл ашиглан компьютер програмчлах	0%	0%	7%	3%	18%
Ур чадваргүй		19%	6%	15%	15%	19%	41%	Эдгээрээс алийг ч чадахгүй	50%	50%	23%	32%	6%

Е БҮЛЭГ- ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙН ХАМГААЛАЛТ БОЛОН НУУЦЛАЛ

Судалгаанд оролцогчдын 58 хувь нь цахим халдлагаас хамгаалдаггүй гэж хариулсан ба бүх насны бүлгийнхний хувьд **мэдээлэл технологийн мэдлэг дутмаг**, хэрэгцээ шаардлага гардаггүй гэсэн хариулт нийтлэг байна. Мэдээлэл технологийн мэдлэгийн түвшин нэмэгдэхэд хамгаалалтыг хэрэгслийн үр ашигт байдлыг судлан иргэд өөрсдийн цахим орчин дахь мэдээллийн аюулгүй байдлыг хангах боломжтой байна. Цахим хамгаалалттай иргэдийн хувьд нууц үгээр хамгаалах нь хамгийн түгээмэл бөгөөд програм хангамж болон өөр серверт, үүлэн орчинд хадгалах хамгаалалтын хувь тэнцүү байна.

58%

Цахим халдлагаас хамгаалдаггүй

	Насны бүлэг					Шалтгаан	Боловсролын түвшин				
	18-25	26-35	36-45	46-55	56-с дээш		Бага	Суурь	Бүрэн дунд	Тусгай дунд	Дээд
51%	33%	57%	49%	48%	67%	IT талын мэдлэг, мэдээлэл дутмаг	100%	100%	52%	53%	49%
3%	6%	3%	3%	7%	0%	Хэт өндөр үнэтэй	0%	0%	5%	5%	2%
6%	6%	5%	5%	9%	4%	Үр өгөөжгүй	0%	0%	6%	5%	7%
40%	56%	35%	43%	37%	30%	Хэрэгцээ шаардлага гардаггүй	0%	0%	38%	37%	42%

Жич: Түүврийн тоо N=192


42%

Цахим халдлагаас хамгаалдаг

	Насны бүлэг					Хамгаалалт	Боловсролын түвшин				
	18-25	26-35	36-45	46-55	56-с дээш		Бага	Суурь	Бүрэн дунд	Тусгай дунд	Дээд
62%	53%	60%	57%	71%	69%	Нэвтрэх нууц үг	0%	33%	63%	83%	53%
20%	22%	20%	27%	24%	6%	Програм хангамжууд	0%	67%	17%	0%	26%
19%	26%	20%	17%	6%	25%	Мэдээллээ өөр төхөөрөмж, сервер дээр давхар хадгалах	0%	0%	20%	17%	21%

Жич: Түүврийн тоо N=138


Цахим халдлагын төрлүүд




- Хуурамч мессеж хүлээн авснаар санхүүгийн алдагдал хүлээх
- Вирусээс болж мэдээлэл, цаг хугацаа алдах, төхөөрөмж гэмтэх
- Интернэт дээр байршуулсан мэдээллээ хууль бусаар ашиглуулах
- Төлбөрийн карт ашигласны улмаас санхүүгийн алдагдал хүлээх
- И-мэйл хаягаа бусдад алдах

Е БҮЛЭГ- ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙН ХАМГААЛАЛТ БОЛОН НУУЦЛАЛ

Судалгаанд оролцогчдын 64 хувь нь “сүүлийн 3 сарын хугацаанд цахим орчинд худал/ эргэлзээтэй мэдээлэл” үзсэн ба тэдний 25 хувь нь мэдээллийн агуулгыг шалгасан. Агуулга шалгаж буй хамгийн түгээмэл хэлбэр нь төстэй мэдээлэлтэй харьцуулалт хийх байна. Хуурамч мэдээллийн агуулгыг шалгадаггүй гэж хариулсан иргэдийн 55 хувь нь тухайн эх сурвалжийг албан ёсны бус гэдгийг мэддэг, 25 хувь нь хэрхэн шалгахаа мэддэггүй гэж хариулсан.



- Эх сурвалжийг шалгах эсвэл интернетээс ижил төстэй мэдээлэл хайх
- Мэдээллийн талаарх интернэт дэх хэлэлцүүлэгт оролцох эсвэл унших
- Мэдээллийг бусад хүмүүстэй ярилцах, интернетээс өөр бусад эх сурвалжийг ашиглах






Жич: Түүврийн тоо N=330



Е БҮЛЭГ- ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙН ХАМГААЛАЛТ БОЛОН НУУЦЛАЛ

Цахим орчинд хувийн мэдээлэл хамгаалалтын тохиргоо болон хамгаалах хэрэгслүүдийг бүрэн дундаас дээш боловсролтой, мөн 18-35 насны иргэд бусад бүлгээс илүүтэй ашигладаг байна. Цаашлаад иргэдээс цахим орчинд хувийн мэдээллийг цуглуулах Cookies тохиргоо болон түүнийг хязгаарлах үйлдэл хийдэг эсэх талаар асуухад 10 хүн тутмын 1 нь л энэхүү тохиргоогоор мэдээллээ хамгаалдаг.



ЦАХИМ ОРЧИН ДАХЬ МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ

01

Арилжааны банкны эрхээр E-Mongolia системд нэвтэрч байгаа нь иргэдэд ойлгомжгүй, найдваргүй санагддаг ба мэдээлэл алдагдах, ямар хуулийн зохицуулалтын хүрээнд хэрхэн мэдээлэл солилцож байгаа тухай иргэд мэдээлэлгүй байна. Иргэдийн хамгийн түгээмэл ашигладаг хамгаалалт нь нууц үг бөгөөд ур чадвараас хамааран нэмэлт төхөөрөмжөөр баталгаажуулах зэргээр ялгаатай байна.

1

ИРГЭДИЙН МЭДЛЭГ, УР ЧАДВАРААС ХАМААРДАГ

“Тэмдэгт, тоо, том, жижиг үсгээс бүрдсэн нууц үгээр мэдээллээ хамгаалдаг.”

/18-30 настай иргэн/

“Өөр төхөөрөмжөөс ороход давхар код нэхдэг тохиргоотой.”

/18-30 настай иргэн/

“Үйлчилгээ авах хэрэгцээ байдаг ч тэр бүр нууц үгээ санадаггүй, блокчлох ахин орж чадахгүй болоод хүүхдүүдээрээ л оруулдаг.”

/50+ иргэн/

2

ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАЛТАД ИТГЭДЭГГҮЙ

“Аппликейшнууд банкны эрхээр нэвтрэхэд миний мэдээллийг ямар хариуцлагын хүрээнд солилцож байгаа болон иргэдийн мэдээллийг хэрхэн хамгаалж байгаа тухай мэдээлэлгүй.”

/18-30 настай иргэн/

3


МАБ-Г НЭМЭГДҮҮЛЭХ

Байгууллага: “Төрөөс хувийн хэвшил болон төрийн байгууллагуудын хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангахтай холбоотой шаардлага тавих хэрэгтэй. Цахим үйлчилгээнд шилжихэд иргэдийн бүх мэдээлэл эрсдэлд орж байгаа.”

/50+ настай иргэн /

Иргэд: “50+ настай иргэд нэвтрэх кодоо мартах, системээс гарч чадахгүй тул мэдээллээ алдах эрсдэл хамгийн их. Эдгээр хүмүүст зориулсан энгийн хэрнээ, хамгаалалт сайтай систем аппликейшндээ хөгжүүлэх хэрэгтэй”

/18-30 настай иргэн/



Банкны харилцагчид данснаасаа мөнгөө алдах тохиолдол маш их байдаг нь хэрэглэгчийн цахимтай холбоотой МАБ-н мэдлэг муу байгаатай холбоотой. Иймд цахимд шилжихэд эхлээд иргэдэд МАБ-н мэдлэг олгох, түүний хор уршгийн талаар таниулах хэрэгтэй. */Иргэдийн ФБЯ-аас/*



Ү БҮЛЭГ- ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ТУРШЛАГА

Судалгаанд оролцогчдоос хамгийн сүүлд төрийн үйлчилгээ авсан байгууллага болон үйлчилгээг тодруулахад эмнэлгийн үйлчилгээнээс гадна харъяа дүүрэг хороо, НҮНТ-өөр үйлчлүүлэх хандлага хамгийн өндөр байсан ба эдгээр байгууллагуудаас иргэд халамжийн үйлчилгээ болон нийгмийн даатгалын үйлчилгээ авсан тохиолдол хамгийн өндөр хувьтай байна. Иргэдийн 87 хувь нь хувийн зорилгоор үйлчилгээ авсан ба сар/ улиралд 1 удаа үйлчилгээ авах давтамж 63 хувь байна.

ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН БАЙГУУЛЛАГА



АВСАН ҮЙЛЧИЛГЭЭ



F БҮЛЭГ- ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ТУРШЛАГА




Судалгаанд оролцогчдын 25 хувь нь төрийн үйлчилгээг хамгийн сүүлд цахимаар, 75 хувь нь биечлэн очих байдлаар авсан ба 18-25 насны бүлэг цахим хэлбэрт, 56-с дээш насны бүлэг биечлэн авах хэлбэрт давамгайл байна. Биечлэн үйлчилгээ авсан иргэдийн 33 хувь нь 10 мин хүртэл, 27 хувь нь 11-30 мин, 40 хувь нь 30 минутаас дээш хугацаанд хүлээдэг бол үйлчилгээ авахдаа 50 хувь нь 10 мин хүртэл, 36 хувь нь 30-60 мин, үлдсэн 14 хувь нь 60 минутаас дээш хугацааг зарцуулдаг байна. Харин цахим үйлчилгээ авсан иргэдийн 71 хувь нь 10 мин хүртэл хугацаанд үйлчилгээгээ авсан.



- Холбогдох төрийн байгууллагад очдог
- Төрийн анхан шатны үйлчилгээний нэгж /Хороо/
- e-mongolia.mn веб сайт

- Дүүргийн нэг цэгийн үйлчилгээ
- Нийслэлийн нэгдсэн үйлчилгээний төв
- Гар утасны аппликейшн

Хүлээлгийн хугацаа



- 5 хүртэл минут
- 11-30 минут
- 1 цагаас дээш
- 6-10 минут
- 31 минутаас 1 цаг




Н БҮЛЭГ- ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР

Иргэдээс төрийн үйлчилгээний мэдээллийг ямар сувгаар хүлээн авдаг болохыг тодруулахад насны бүлэг болон ажил эрхлэлтээс үл хамааран лавлах утсаар залган мэдээлэл авдаг хувь хамгийн өндөр, холбогдох байгууллагад биеэр очдог гэж хариулсан бүлэгт өндөр настан иргэд давамгай, цахим хуудсаар мэдээлэл авдаг бүлэгт 18-35 насныхан болоод ажил олгогч, оюутан иргэд, танил талаасаа мэдээлэл авдаг бүлэгт 46-с дээш насныхан, телевизээр мэдээлэл авдаг бүлэгт өндөр наснууд давамгай байна. Төрийн үйлчилгээ үзүүлж буй платформуудаас e-barimt, e-Mongolia, UB bus аппликейшнууд хамгийн өргөн хэрэглээтэй байна.

Насны бүлэг					Мэдээллийн суваг	Ажил эрхлэлт						
18-25	26-35	36-45	46-55	56-с дээш		Цалинтай ажиллагч	Ажил олгогч	Оюутан	Өндөр настан	Хувиараа	Ажилгүй	
29%	21%	27%	34%	21%	Лавлах утсаар	27%	20%	24%	20%	25%	31%	26%
13%	18%	25%	19%	32%	Холбогдох байгууллагад биеэр очдог	18%	20%	14%	32%	22%	22%	22%
23%	28%	18%	18%	10%	Төрийн байгууллагын веб сайтаас	22%	30%	26%	10%	22%	19%	19%
16%	14%	17%	19%	19%	Танил тал, найз нөхдөөсөө	18%	10%	15%	19%	14%	14%	17%
20%	19%	12%	7%	10%	Тухайн төрийн байгууллагын сошиал хуудсаар	14%	20%	21%	10%	15%	13%	14%
0%	0%	1%	3%	9%	Телевиз	1%	0%	0%	9%	1%	1%	2%

ЛАВЛАХ УТСААР
төрийн үйлчилгээний мэдээллийг авдаг



МЭДЭЭЛЛИЙН СУВГУУДЫН
танигдсан байдал

■ Байнга ашигладаг ■ Нэг удаа ашигласан ■ Ашиглаж үзсэн боловч зорилгоо биелүүлж чадаагүй ■ Сонссон төдий ■ Мэдэхгүй

ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АППЛИКЕЙШН

Төрийн үйлчилгээний Манай хороо аппликейшны ач холбогдлыг иргэд төдийлөн үнэлэхгүй байна. Учир нь энэхүү аппликейшны талаар иргэд ихэвчлэн байршил харах зорилгоор ашигладаг ч Google map илүү ойлгомжтой тул хэрэгцээгүй гэж үзэж байна. Харин Smart UB аппликейшны хувьд **орон нутгийн хөгжлийн сангийн** санал асуулга авах нь зүйтэй ч санал авч буй **давтамж хангалтгүй**, санал хураалтаас цааших **мэдээлэл иргэдэд хүрдэггүйд** сэтгэл дундуур байна. Эдгээр аппликейшны хэрэглээтэй холбоотой иргэдийн сэтгэгдэл сөрөг байна.

Smart UB gogo MONG ЗОРИЛГОО ХҮРЧ ЧАДДАГГҮЙ

АППЛИКЕЙШН ТАТАХАД ХҮНДРЭЛТЭЙ

- Үйлдлийн систем/ утасны хүчин чадлаас хамааран татагдахгүй байх
- Серверт алдаа гарах, ачааллаад хариу үйлдэл үзүүлэхгүй байх

НЭВТРЭХЭД ХҮНДРЭЛТЭЙ, UI МУУТАЙ

- Интернеттэй орчинд ч нэвтрэхэд алдаа гардаг
- Аппликейшнд нэвтрэхэд мэдээний сайт шиг, агуулж байгаа мэдээлэл, функцууд бусад системүүдтэй давхардалтай

САНАЛ АВАХ ДАВТАМЖ ЦӨӨН, ЭРГЭН МЭДЭЭЛЭЛГҮЙ

- Саналыг ядаж сар бүр авах хэрэгтэй
- Илгээсэн санал, гомдлын төлөв, шийдвэрлэлт, эрэмбэ нээлттэй бус

Манай хороо ЗОРИЛГО ОЙЛГОМЖГҮЙ

АППЛИКЕЙШН БАЙХГҮЙ

- Утасны аппликейшн татагддаггүй, нэрээр нь хайгаад гарч ирдэггүй

ГАР УТСАНД ТОХИРОМЖГҮЙ

- Нэг цэс сонгохоор олон тэмдэгтүүд бөөгнөрч гарч ирэх нь компьютер болон утсанд алл алинд нь харахад хүндрэлтэй, зарим цэснүүдэд мэдээлэл байхгүй

ЗОРИЛГО ОЙЛГОМЖГҮЙ

Саналыг хүлээн авдаг ч эргэн мэдээллэдэггүй, төлвийг харуулдаггүй Smart UB аппликейшнтэй зорилгын хувьд давхардалтай, зорилго нь иргэдэд тодорхойгүй байна ”

“Иргэдэд нийслэлийн мэдээллийг хүртээмжтэй хүргэх гэж буй зорилго нь зөв ч **мэдээлэл нь их хуучин, харахад хүндрэлтэй.** Эдгээр мэдээллийг ikon.mn, gogo.mn гэх мэт бусад мэдээллийн сайтаас авах боломжтой. Мобиком, Юнителийн аппликейшн шиг хэрэглэхэд хялбар болгочихвол хүмүүс ашиглана.”

/Иргэдийн ФБЯ-аас/



САЙЖРУУЛАЛТЫН САНАЛ

- ✓ Бүх төрлийн төхөөрөмжид тохирч ажиллах боломжтой байх
- ✓ UI/UX дизайныг сайжруулах, хэрэглэгчийн туршлагыг судалж, сайжруулдаг байх
- ✓ Аппликейшнуудын зорилго/ үйл ажиллагааны давхардлыг арилгах
- ✓ Тухайн аппликейшны зорилго, шийдвэрлэх асуудал, иргэдэд хүрэх өгөөжийг танилцуулах, хэрэглээнд хэвшүүлэх
- ✓ Иргэдийн хэрэглэж дассан ФБ гэх мэт аппликейшн шиг хялбар болгох
- ✓ Саналын мэдээлэл, төлөв иргэдэд нээлттэй, ил тод байх
- ✓ Төсвийн хуваарилалт жилд 1 удаа хийгддэг ч иргэдийн саналыг тухайн жилийн турш авдаг байх

ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СЭТГЭЛ ХАНАМЖ БОЛОН ЧУХАЛЧЛАХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Цахим үйлчилгээний энэхүү үнэлгээгээр “Төрийн цахим үйлчилгээний хэрэглэгчдэд хүрэх өгөөж” үзүүлэлт хамгийн сэтгэл ханамжтай үзүүлэлтээр 4.24 оноо, “төрийн үйлчилгээний веб хуудас болон гар утасны аппликейшнуудын хариу үйлдэл” хамгийн сэтгэл дундуур буюу 3.15 оноотой үнэлэгдсэн байна. Чухалчлах байдлын хувьд “Веб хуудас болон гар утасны аппликейшнуудын нууцлал, аюулгүй байдал”, “Төрийн цахим үйлчилгээний хэрэглэгчдэд хүрэх өгөөж” үзүүлэлтүүдэд иргэд хамгийн өндөр ач холбогдол өгч 4.24 оноогоор үнэлсэн. Эсрэгээрээ хамгийн ач холбогдол багатай үзүүлэлтээр “Веб хуудас болон гар утасны аппликейшнуудын формат” 4.13 оноогоор үнэлэгдсэн.



СИСТЕМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА: Төрийн үйлчилгээний веб хуудас болон гар утасны аппликейшнуудын ашиглахад хялбар байдал

СИСТЕМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА: Төрийн үйлчилгээний веб хуудас болон гар утасны аппликейшнуудын бэлэн байдал

ХЭРЭГЛЭГЧИЙН ДЭМЖЛЭГ: Төрийн цахим үйлчилгээний хэрэглэгчдийн өгөөж

ХЭРЭГЛЭГЧИЙН ДЭМЖЛЭГ: Төрийн үйлчилгээний веб хуудас болон гар утасны аппликейшнуудын харилцаа холбоо

ХЭРЭГЛЭГЧИЙН ДЭМЖЛЭГ: Төрийн үйлчилгээний веб хуудас болон гар утасны аппликейшнуудын хариу үйлдэл


КОНТЕНТ: Төрийн үйлчилгээний веб хуудас болон гар утасны аппликейшнуудын үйлчилгээний талаарх мэдээлэл

ПРОЦЕДУР: Төрийн үйлчилгээний веб хуудас болон гар утасны аппликейшнуудын нууцлал, аюулгүй байдал


ПРОЦЕДУР: Төрийн үйлчилгээний веб хуудас болон гар утасны аппликейшнуудын найдвартай байдал

ПРОЦЕДУР: Төрийн үйлчилгээний веб хуудас болон гар утасны аппликейшнуудын интерактив /харилцан үйлчлэл/ байдал

КОНТЕНТ: Төрийн үйлчилгээний веб хуудас болон гар утасны аппликейшнуудын формат




ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СЭТГЭЛ ХАНАМЖ БОЛОН ЧУХАЛЧЛАХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ




Цахим үйлчилгээний энэхүү үнэлгээгээр “Төрийн цахим үйлчилгээний хэрэглэгчдэд хүрэх өгөөж”, цаашид хэрэглэх байдал, аппликейшны найдвартай байдал зэрэг үзүүлэлтүүд хамгийн сэтгэл ханамжтай болон чухал үзүүлэлтээр, аппликейшны нууцлал, аюулгүй байдал, бэлэн байдал, ашиглахад хялбар байдал аппликейшны санал гомдол авах, үйлчилгээгээ авч чадаагүй үед нэмэлт мэдээлэл өгч харилцан үйлчлэх байдал сэтгэл ханамжгүй ч чухалчлах байдал өндөртэй үзүүлэлт тул эдгээр үзүүлэлтүүдий сайжруулах шаардлагатай байна. Гар утасны болон цахим хуудасны формат нь сэтгэл ханамжтай ч иргэдийн хувьд чухалчлах байдал багатай байна.

ТӨРИЙН УЛАМЖЛАЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СЭТГЭЛ ХАНАМЖ БОЛОН ЧУХАЛЧЛАХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Төрийн уламжлалт үйлчилгээний үнэлгээрээр иргэд өөрт байгаа “мэдээлэл” болон **үйлчилгээг хангалттай түвшинд авч чадсан эсэхэд 5 онооноос 3.42** оноо буюу бусад бүлгүүдээс харьцангуй өндөр үнэлж, “үйлчилгээний орчин болон ажилтан”-ны бүлэгт хамгийн сэтгэл ханамжгүй байдаг гэж үзэн 3.19 оноогоор үнэлсэн. Чухалчилж буй үзүүлэлтийг хувьд иргэдийн хамгийн сэтгэл дундуур үзүүлэлт болох “үйлчилгээний орчин болон ажилтан”-ны бүлэг 4.46 оноогоор хамгийн чухал үзүүлэлт болж, “үйлчилгээний хугацаа” бүлэг 4.36 оноогоор чухалчлах байдал багатай үзүүлэлтээр үнэлэгдсэн байна.



ТӨРИЙН УЛАМЖЛАЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СЭТГЭЛ ХАНАМЖ БОЛОН ЧУХАЛЧЛАХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ



Энэхүү үнэлгээгээр уламжлалт үйлчилгээний сэтгэл ханамж 3.2 буюу дундаж, чухалчлах байдал бүх үзүүлэлтийн хувьд өндөр буюу 4.38 үнэлгээтэй байна.


Бүлэг тус бүрээр харвал үйлчилгээний хугацаа нь бусад үзүүлэлттэй харьцуулахад сэтгэл ханамж болон чухалчлах байдал хамгийн багатай үзүүлэлтээр, үйлчилгээний ажилтны мэдлэг болон үйлчилгээний орчин нь сэтгэл ханамж багатай ч хамгий чухал үзүүлэлтээр, авахыг хүссэн үйлчилгээнийхээ талаар хэр мэдээлэлтэй байдаг тухай үзүүлэлт нь бусад үзүүлэлттэйгээ харьцуулахад сэтгэл ханамж өндөртэй ч чухал үзүүлэлтээр, үйлчилгээ авах үед ажилтнуудын хариуцлагатай, бэлэн байдал нь сэтгэл ханамж дунджаас өндөр ч чухалчлах байдал багатай үзүүлэлт байна.

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АВАХ ХЭЛБЭР /2018-2020 ОНЫ ӨӨРЧЛӨЛТ/


2018-2020 оны хооронд нийслэлээс үзүүлж буй үйлчилгээний хэлбэрийг харвал уламжлалт үйлчилгээний хувь өссөн хандлагатай, цахим үйлчилгээний хувь буурсан байна. Цахим засаглалын бэлэн байдлын үнэлгээний мэдээлэл цуглуулалт 2021/09-2021/10 сард хийдсэн бөгөөд иргэдээс хамгийн сүүлд ямар хэлбэрээр үйлчилгээ авсаныг тодруулахад тэдний 75 хувь нь биечлэн, 25 хувь нь цахимаар гэж хариулсан.

Үйлчилгээний хэлбэр	2018	2019	2020
Уламжлалт	55%	66%	79%
Аж ахуйн нэгж	0%	0%	1%
Иргэн	16%	10%	11%
Иргэн болон Аж ахуйн нэгж	39%	56%	67%
Цахим	45%	34%	21%
Аж ахуйн нэгж	3%	3%	3%
Иргэн	0%	0%	0%
Иргэн болон Аж ахуйн нэгж	42%	31%	18%
Нийт	100%	100%	100%


Төрийн үйлчилгээ авч буй хэлбэр




Иргэдийн хамгийн сүүлд төрийн үйлчилгээ авсан хэлбэр




ААНБ



Иргэн, ААНБ



Иргэн




СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ҮР ДҮН


1 МЭРГЭЖИЛТНИЙ ҮНЭЛГЭЭ

2 ИРГЭДИЙН ҮНЭЛГЭЭ

3 ААНБ-ЫН ҮНЭЛГЭЭ



ААНБ-ЫН БЭЛЭН БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ БҮЛГҮҮД




СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ, СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

“Цахим засаглалын бэлэн байдлын үнэлгээ”–ний аж ахуйн нэгж байгууллагын судалгааг төрийн үйлчилгээг сүүлийн 3 сарын хугацаанд ядаж нэг удаа авсан байх гэсэн шалгуурын хүрээнд нийслэлд үйл ажиллагаа эрхэлдэг 104 байгууллагаас CATI буюу утсаар судалгаа авах байдлаар хийж гүйцэтгэсэн. Оролцогчдын 83 хувийг компани, 22 хувийг үйлчилгээний салбар эзэлж байна.


ТООН СУДАЛГАА
Computer Assisted Telephone Interviewing (CATI)

104 САТИ ААНБ



ДУНДАЖ АЖИЛТНЫ ТОО

155 АЖИЛТАН




Үйлчилгээ	22%
Бөөний/жижиглэн худалдаа;...	14%
Барилга	12%
Эрүүл мэнд ба нийгэм	9%
ХАА, ойн аж ахуй, загас, ан агнуур	5%
Боловсруулах үйлдвэрлэл	5%
Байр, сууц болон хоол хүнсээр...	5%
Цахилгаан, хий, уур,...	4%
Санхүү/даатгалын үйл ажиллагаа	4%
Усан хангамж; бохир ус, хог,...	3%
Өрхийн үйл ажиллагаа	2%
Үл хөдлөх хөрөнгө	2%
Уул уурхай, олборлолт	2%
Урлаг, үзвэр, тоглоом наадам	2%
Тээвэр/ агуулахын үйл ажиллагаа	2%
Төрийн удирдлага ба батлан...	2%
Олон улсын байгууллага, суурин...	2%
Мэргэжлийн, шинжлэх ухаан...	2%
Боловсрол	2%
Захиргааны /дэмжлэг үзүүлэх	1%




ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

А БҮЛЭГ- БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ХОЛБОЛТ



ААНБ-уудын 93 хувь нь нэгдсэн байдлаар интернетэд холбогдсон ба тэдний 37 хувь нь 1 Gbit, 25 хувь нь 2Mbit хүртэл хурдны интернеттэй. Судалгаанд оролцогч байгууллагуудын дунджаар “нэг байгууллагын ажилтнуудын 51 хувь нь өдөр тутамдаа өдөр тутамдаа компьютер ашигладаг. Үүнээс суурин компьютерийн ашиглалт 49 хувь, зөөврийн компьютер ашиглалт 39 хувь байна.



ДУНДЖААР



өдөр тутамдаа компьютер ашигладаг



- 1 Gbit/s -дээш
- 2 Mbit/s хүртэл
- 10 Mbit/s хүртэл
- 30 Mbit/s хүртэл
- 100 Mbit/s хүртэл




В БҮЛЭГ- БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАС

Судалгаанд оролцогч ААНБ-уудын 31 хувь нь цахим хуудасгүй ба тэдний дундаж ажилчдын тоо цахим хуудастай байгууллагын дунджаас 10 дахин бага байна. Үйл ажиллагааны чиглэлээр харвал Үйлчилгээний бөөний болон жижиглэн худалдаа, барилга, ХАА, боловсруулах үйлдвэрлэл зэрэг чиглэлүүд байна. Тэдний 71 хувь нь үйл ажиллагаанд нь цахим хуудас шаардлагагүй гэж үзсэн.



С БҮЛЭГ- МЭДЭЭЛЛИЙН УДИРДЛАГЫН ХЭРЭГСЛҮҮД

ААНБ-уудын 71 хувь нь дотоод сүлжээгээр холбогдсон ба тэдний 31 хувь нь ERP, EDI, CRM, RFID зэргийг, 22 хувь нь 2 болон түүнээс дээш сүлжээг хослуулан ашигладаг. Дотоод сүлжээгүй байгууллагуудын шалтгааныг тодруулахад үйлчилгээгээр хангах байгууллага байхгүй, хүний нөөцийн чадавхгүй зэрэг байна.



Жич: Түүврийн тоо
N=74



Жич: Түүврийн тоо
N=30



С БҮЛЭГ- МЭДЭЭЛЛИЙН УДИРДЛАГЫН ХЭРЭГСЛҮҮД

Харилцагч нараас цахим хуудсаараа дамжуулан захиалга хүлээн авдаг нийт 28 байгууллагын ашигладаг хувьд 43% - олон нийтийн сүлжээгээр, 29% - албан ёсны цахим хуудсаар дамжуулан бараа, бүтээгдэхүүн үйлчилгээний нийлүүлэлтийн мэдээллээ харилцагч нартаа мэдээлэлдэг ба үлдсэн 29 хувь нь нийлүүлэлтийн мэдээллээ цахимаар мэдээлдэггүй. Судалгаанд оролцсон байгууллагуудын **дундаж ажилтнуудын тооноос их** ажилтнуудтай байгууллагууд **E-barimt болон цаасан хосолсон** хэлбэрээр нэхэмжлэл илгээх болон хүлээн авдаг, **бага** ажилтантай байгууллагууд **цаасан болон и-мэйл, чатаар** нэхэмжлэл илгээх болон хүлээн авдаг байна.

27% Нийлүүлэлтийн элхээний удирдлагатай
Supply chain management



43%

Олон нийтийн сүлжээгээр

29%



Албан ёсны цахим хуудсаар


29%




Цахимаар мэдээлдэггүй

Жич: Түүврийн тоо N=28

ААНБ-уудын нэхэмжлэхээ илгээдэг хэлбэр, хувиар



ААНБ-уудын нэхэмжлэх хүлээн авдаг хэлбэр, хувиар




Жич: Түүврийн тоо N=104




D БҮЛЭГ- АЮУЛГҮЙ БАЙДАЛ, НУУЦЛАЛ

Судалгаанд оролцож буй ААНБ-уудын хувьд “мэдээллийн аюулгүй байдлыг зохицуулах дотоод дүрэм, журамтай” байгууллагын эзлэх хувь нь “мэдээллийн нууцлалыг хангах дотоод дүрэм, журамтай” байгууллагын эзлэх хувиас **18 хувиар бага** түвшинд байна. Өөрөөр хэлбэл байгууллагуудын хувьд мэдээллийн аюулгүй байдлыг хангахаас илүү дотоод мэдээллийн нууцлалыг хангах тал дээр илүү анхаардаг гэсэн дүгнэлт хийгдэхүйц байна. Нийт байгууллагын 16 хувь нь мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлтэй тулгарч, тэдний 47 хувь нь ямар нэгэн байдлаар хохирол амссан. Байгууллагынхаа МАБ-г болон хэрэглэгчийн мдээллийг хамгаалах хамгийн түгээмэл хэлбэр нь нэвтрэх эрх.



МАБ-н хамгаалалт




Хувийн мэдээллийн хамгаалалт




Е БҮЛЭГ- ЦАХИМ ЗАСАГЛАЛ

Судалгаанд оролцсон ААНБ-уудын 86 хувь нь төрийн үйлчилгээ авахдаа интернэт ашигладаг ба бүх төрлийн татвар, нийгмийн даатгал төлөлт, байгууллагын тодорхойлолт, лавлагаа зэрэг үйлчилгээг хамгийн өндөр давтамжтай авдаг. Цахим үйлчилгээ авдаг ААНБ-уудад тулгардаг хамгийн нийтлэг хүндрэл нь ямар төрийн үйлчилгээ цахимжсан, хэрхэн ямар платформоор үйлчилгээгээ авах талаар мэдээлэл хомс, цахим үйлчилгээ авах шат дамжлага хэт олон, төр өөрт байгаа мэдээллийг дахин шаардан цагийн болон санхүүгийн нөөцийг үр ашиггүй байдлаар үрдэг гэсэн хүндрэлүүд байна. Давуу талын хувьд цаг хугацаа хэмнэх, зардал буурах, төрийн үйлчилгээний ил тод байдал зэрэгт эерэг нөлөөтэй гэсэн хариултауд хамгийн их давтамжтай байна.



■ интернет ашигладаг
■ интернет ашигладаггүй



Төрийн ЦАХИМ үйлчилгээнд өгч буй үнэлгээ

Жич: Түүврийн тоо




Төрийн УЛАМЖЛАЛТ үйлчилгээнд өгч буй үнэлгээ


Уламжлалт хэлбэрээр авч буй төрийн үйлчилгээний төрөлд цаасан суурьтай бичиг баримтууд болох **нийгмийн даатгал болон татварын тайлан, тусгай зөвшөөрөл авах/сунгалт хийлгэх, байгууллагын лавлагаа, тодорхойлолт, үл хөдлөх хөрөнгийн бичиг баримт, тендерт оролцохтой холбоотой үйлчилгээг** биечлэн авдаг ба эдгээр үйлчилгээний чанар, хүртээмжийг 2.6 гэж үнэлсэн. Учирч буй түгээмэл хүндрэл нь үйлчилгээ авахад олон шат дамжлагатай, төр өөрт байгаа мэдээллийг дахин бүрдүүлэхийг шаардах, үйлчилгээ үзүүлж буй ажилтнуудын ажлын цаг ашиглалт сул, хүний нөөц хүрэлцээгүй байдлаас болж тайлбар зөвлөгөө өгдөггүй гэсэн сул талууд дурдагдаж байна.

Үйлчилгээний төрөл



Хүндрэл





НИЙТ




ДУНДЖААС ИХ n=16



ДУНДЖААС БАГА n=37

38%
Дунджаас их
n=13

62%
Дунджаас бага
n=21



НИЙТ

4%
Дунджаас их
n=3

96%
Дунджаас бага
n=67

F БҮЛЭГ- ЦАХИМ УР ЧАДВАР



The Asia Foundation

Судалгаанд хамрагдсан ААНБ-уудын 51 хувь нь мэдээллийн технологи хариуцсан ажилтантай. Байгууллага тус бүрийн ажилчдын тооноос хамаарч дунджаас их тооны ажилтантай байгууллага дунджаар 18, дунджаас бага тооны ажилтантай байгууллага дунджаар 2 мэдээлэл технологийн ажилтантай ажилладаг.


Шаардлагатай хүний нөөц бүрдүүлэхэд цалингийн хэт өндөр шаардлага, мэдээлэл технологийн ур чадвар хангалтгүй, цахим болон мэдээллийн технологитой холбоотой төсөл хариуцах, зохион байгуулах бусадтай хамтран ажиллах зэрэг ур чадвар сул байх гэх мэт хүндрэлүүд нь байгууллагын үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ зэргээс үл хамааран тулгардаг байна.

МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН АЖИЛТАН СОНГОН ШАЛГАРУУЛАХАД



F БҮЛЭГ- ЦАХИМ УР ЧАДВАР

MT-н тасралтгүй ажиллагааг ханган ажиллаж байгаа хэлбэрийг тодруулахад цахим хуудасны хөгжүүлэлт, засвар үйлчилгээ, мэдээллийн технологийн архитектур хөгжүүлэх зэрэг үйлчилгээг дотооддоо хийж гүйцэтгэдэг. Сервер, компьютер, принтер, дотоод сүлжээ, МАБ болон программ хангамжийн үйлчилгээг гадны байгууллагаар хийж гүйцэтгүүлдэг байна.



Ү БҮЛЭГ- ЦАХИМ УР ЧАДВАР

MT-н тасралтгүй ажиллагааг ханган ажиллаж байгаа хэлбэрийг ажилтнуудын тоогоор ангиллахад **дунджаас их** ажилтантай байгууллагуудын хувьд **MT-н дэд бүтцийн засвар үйлчилгээ, архитектур хөгжүүлэлт зэргийг дотооддоо, МАБ хангах үйлчилгээг гадны байгууллагаар** хийлгэдэг. Харин **дунджаас бага** ажилтантай байгууллагын хувьд өөрсдийн **цахим хуудасны хөгжүүлэлт, засварыг дотооддоо хийх боломжтой, MT-н дэд бүтцийн засвар үйлчилгээ** болон архитектур хөгжүүлэлтийг **гадны байгууллагаар, МАБ болон дотоод сүлжээний засварыг огт хийж** гүйцэтгэдэггүй байна.

Үйлчилгээ авч буй хэлбэр	Үзүүлэлтүүд	Дунджаас их	Дунджаас бага
Компани дотроо	Мэдээлэл технологийн дэд бүтцийн засвар үйлчилгээ /сервер, компьютер, принтер, сүлжээ гм/	81%	25%
	Программ хангамжийн үйлчилгээ	63%	26%
	Цахим бизнесийн системийн хөгжүүлэлт /ERP, CRM, мэдээллийн-сан гм/	50%	15%
	Цахим бизнесийн системийн засвар, үйлчилгээ	63%	20%
	Цахим хуудас хөгжүүлэлт	63%	40%
	Цахим хуудасны засвар, үйлчилгээ	63%	38%
	Мэдээллийн аюулгүй байдлыг шалгах, Программ хөгжүүлэх	56%	25%
Гадны компаниар	Мэдээлэл технологийн дэд бүтцийн засвар үйлчилгээ /сервер, компьютер, принтер, сүлжээ гм/	13%	65%
	Программ хангамжийн үйлчилгээ	38%	66%
	Цахим бизнесийн системийн хөгжүүлэлт /ERP, CRM, мэдээллийн-сан гм/	38%	49%
	Цахим бизнесийн системийн засвар, үйлчилгээ	25%	39%
	Цахим хуудас хөгжүүлэлт	38%	35%
	Цахим хуудасны засвар, үйлчилгээ	38%	38%
	Мэдээллийн аюулгүй байдлыг шалгах, Программ хөгжүүлэх	44%	42%
Огт хийж гүйцэтгэдэггүй	Мэдээлэл технологийн дэд бүтцийн засвар үйлчилгээ /сервер, компьютер, принтер, сүлжээ гм/	6%	10%
	Программ хангамжийн үйлчилгээ	0%	8%
	Цахим бизнесийн системийн хөгжүүлэлт /ERP, CRM, мэдээллийн-сан гм/	13%	36%
	Цахим бизнесийн системийн засвар, үйлчилгээ	13%	41%
	Цахим хуудас хөгжүүлэлт	0%	25%
	Цахим хуудасны засвар, үйлчилгээ	0%	25%
	Мэдээллийн аюулгүй байдлыг шалгах, Программ хөгжүүлэх	0%	33%
	Мэдээллийн технологийн архитектур хөгжүүлэх	6%	36%



G БҮЛЭГ- ЦАХИМ ХӨГЖҮҮЛЭЛТИЙН ЗАРДАЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Судалгаанд оролцсон ААНБ-уудын нийт зардлын дунджаар 11 хувийг мэдээлэл технологи, цахим хөгжүүлэлттэй холбоотой зардал эзэлдэг ба тоног төхөөрөмж, программ хангамжийн зардал хамгийн өндөр хувьтай, үүний дараа мэдээллийн технологийн бусад байгууллагаас зөвлөх үйлчилгээ авах зардал орж байна. Байгууллагуудын цахимтай холбоотой үйлчилгээний төлбөрийн 87 хувь нь шууд худалдан авалт байна.


Нийт төсөвт эзлэх цахим шилжилтийн зардал



Төсөв зарцуулж буй үйл ажиллагаа



Үйл ажиллагаа төлбөрийн хэлбэр



11%

Нийт төсвийн эзэлдэг



БАЙГУУЛЛАГЫН БЭЛЭН БАЙДАЛ

- Хүний нөөцийн ур чадвар дутмаг
- Төсөв санхүүжилт дутмаг
- Хууль эрхзүйн орчин бүрдээгүй
- Нэгдсэн бодлого, уялдаа холбоо дутмаг
- Иргэд, ТББ –уудын оролцоог бүрэн хангадаггүй.

- Цахим шилжилтийн ажлууд эрчимтэй хийгдэж байгаа

ТЕХНОЛОГИЙН БЭЛЭН БАЙДАЛ

ХЭРЭГЛЭГЧИЙН БЭЛЭН БАЙДАЛ

- Ахисан түвшний цахим ур чадвар муу
- Мэдлэг, мэдээлэл дутмаг
- Иргэд, ААНБ –уудын цахим гарын үсгийн хэрэглээ бага.

- Иргэдийн ухаалаг гар утасны хэрэглээ болон аппликэйшны хэрэглээ өндөр
- Интернэт, дата хэрэглээ өндөр
- Бизнесийн байгууллагуудын цахим бэлэн байдал харьцангуй өндөр.

ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧНЫ БЭЛЭН БАЙДАЛ

- Хуулийн төслүүд батлагдаагүй

- 2 хуулийн төсөл УИХ –аар хэлэлцэгдэх шатандаа явж байгаа



СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

- Дэлхийн улс орнууд дижитал эдийн засаг, засгийн газрын чиг хандлагаар хөгжиж байна. Цахим засгийн газар нь илүү ил тод, хэрэглэгч төвтэй (user centric), МХХТ-д суурилан үйл ажиллагаа явуулдаг бол дижитал засгийн газар нь нээлтэй, хэрэглэгч болон өгөгдлийг удирдлага болгосон (user driven, data driven), процесс, үйл ажиллагаанд өөрчлөлтийн менежментийг хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Бид цахим засаглалын бэлэн байдлын үнэлгээг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга, аргачлалын дагуу НЗДТГ, түүний харъяа 34 агентлаг, ННҮТ, ХХМТГ-ийг хамруулан хийж гүйцэтгэлээ. Цахим засаглалын бэлэн байдлын ерөнхий үнэлгээ 58 хувь байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм.
- Нийслэл, түүний харъяа агентлагууд цахим шилжилтэд чиглэсэн алсын хараа, зорилгоо тодорхойлж, төрийн албан хаагчид энэхүү алсын хараа, зорилгыг ойлгож, дэмжин ажиллаж байгаа хэдий ч мэдээлэл солилцоо, хүний нөөц, цахим шилжилт хэрхэн хийх **төлөвлөгөө хангалтгүй**, цахим шилжилт хийх, цахим засаглалын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай **төсөв, санхүүжилтийн эх үүсвэр дутмаг** байгаа нь төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхэд гол саад бэрхшээлийг бий болгож байна.
- **Хэрэглэгч төвтэй загварт** суурилан төрийн үйлчилгээг **суурь зарчмыг бүрэн хангаагүй**, төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцоо хангалтгүй, иргэд, үйлчлүүлэгчдэд чиглэсэн **маркетингийн нэгдсэн бодлого байхгүй** байна. Цахим засаглалын хэрэглэгч төвтэй загварын суурь зармыг хэрэгжүүлэх, хүртээмжтэй байдлын стандартыг хангах, хувийн хэвшил, эрдэм шинжилгээний институтын оролцоог нэмэгдүүлэх нь шаардлагатай.
- Цахим шилжилт хийх, ирээдүйд дижитал засгийн газрыг хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай өөрчлөлтийн менежментийн төлөвлөгөө хангалтгүй, хэрэгжилт сул байна.
- Мэргэшсэн ажилтнуудын тогтвор суурьшил маш бага, цалин урамшууллын систем нь эдгээр ажилтнуудыг тогтоон барих хөшүүрэг болж чадахгүй байна.
- Цахим шилжилтийг манлайлан удирдах төслийн удирдлагын алба/нэгж/ажлын хэсэг/ажилтан хангалтгүй.
- Иргэд, хуулийн этгээд нь төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүлээн авах бэлэн байдал хангагдсан гэж дүгнэж болохоор байна. Гэвч иргэдийн төрийн цахим үйлчилгээг авах сэтгэл ханамжийн дундаж түвшинд байгаа нь хэрэглэгч төвтэй загварыг хэрэгжүүлж чадахгүй байгааг харууж байна.



СУДАЛГААНЫ ЗӨВЛӨМЖ

01

ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧИН, БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ БҮРЭН ШИЙДЭХ

Одоо хэлэлцэгдэж буй хуулийн төслүүдийн уялдаа холбоо, олон улсын стандартад нийцэх байдал, ОУ-ын гол шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж байгаа эсэхэд шинжилгээ хийх, хэлэлцэгдэж буй хуулийн төслүүдийг батлуулах.

ЦАХИМ ШИЛЖИЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТӨСӨВ БАТЛАХ, ХӨРӨНГӨ ОРУУЛАХ

Улсын төсвөөс гадна олон улсын байгууллага, хувийн секторын дэмжлэг, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэн цахим шилжилтийн үйл ажиллагааг эрчимжүүлэх техник, технологийн хэрэгслүүд, программ хангамж, сүлжээний хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлэх хэрэгтэй.

02

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН МЭДЛЭГ УР ЧАДВАРТАЙ ХҮНИЙ НӨӨЦИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

Цалин урамшууллаас гадна нийгмийн асуудал /орон байрны хөнгөлөлттэй зээл, хүүхдийн сургууль цэцэрлэгт хамрагдалт гм/-ыг шийдэж бусад хувийн байгууллагад ажиллахаас илүү давуу тал олгосноор чадварлаг хүний нөөцийг хадгалж үлдэх боломжтой. Сургалтын чанарыг сайжруулж технологийн дэд бүтцийн үзүүлэлтүүдээс үнэлгээ багатай чиглэлд сургалт олгох нь оновчтой.

03

ИРГЭДИЙН ЦАХИМ УР ЧАДВАРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

Иргэдийн цахим ур чадварыг сайжруулахад их, дээд сургууль, ЕБС –ийн сургалтын хөтөлбөр, арга зүйг зэргийг харж үзэх хэрэгтэй. Суурь боловсрол, дээд боловсролоор дамжуулан ахисан түвшний ур чадварыг олгох шаардлагатай байна.

04

СУДАЛГААНЫ ЗӨВЛӨМЖ

05

БИЗНЕС, ААН-Д ҮЗҮҮЛЖ БУЙ УЛАМЖЛАЛТ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЦАХИМЖУУЛАХ

Бизнес, ААН-д үзүүлж буй уламжлалт төрийн үйлчилгээний сэтгэл ханамж маш бага буюу 2,6 үнэлгээтэй байна. Мөн бизнесийн байгууллагад үзүүлж буй төрийн үйлчилгээний шат дамжлага олон, хээл хахууль, хүнд суртал хамгийн их байдаг тухай судалгаанд оролцогчид хамгийн ихээр дурдаж байв. Иймд энэ талын үйлчилгээнүүдийг цахимд шилжүүлснээр төрийн үйлчилгээний цахим шилжилтэд маш өндөр ахиц дэвшил авчрах болно. Нөгөөтээгүүр бизнес, ААН-үүдийн бэлэн байдал өндөр байгаа учраас цахим үйлчилгээний хүртээмж, үйлчилгээг авах байдал хамрах хүрээ өндөртэй байх болно.

06

ЦАХИМ ШИЛЖИЛТИЙН ПРОЦЕСС, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

Цахим засаглал, цахим шилжилттэй холбоотой үйл ажиллагаа, төлөвлөгөө, системд сонгуулийн 4 жилийн цикл нөлөөлж байдаг тухай оролцогчид дурдсан. Энэ нь цахим шилжилтийн үйл ажиллагаа, төлөвлөгөө, стратеги тогтвортой явагдахад хүндрэл учруулдаг. Иймд төр засгаас хараат байдлыг халахад олон улсын загвар, системд суурилах, үйл ажиллагаагаа анхнаасаа үндэслэлтэй, ул суурьтай төлөвлөх нь чухал юм.

07

ЗӨВ, ОНОВЧТОЙ RE-ENGINEERING ХИЙХ

Цахим шилжилттэй холбоотой үйл ажиллагааг зөв re-engineering –ээр хийх хэрэгтэй. Одоо байгаа процессыг илүү ухаалаг, хурдан шуурхай болгох шаардлагатай.



СУДАЛГААНЫ ЗӨВЛӨМЖ

08

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СИСТЕМҮҮДЭД ИНТЕГРАЦИ ХИЙХ

Төрийн үйлчилгээнд ашиглаж буй системүүд болон төрийн байгууллагын байгууллагын дотоод үйл ажиллагааны системүүдийн тогтвортой ажиллагааг хангах, систем хоорондын шаардлагатай интеграцийг хийж мэдээлэл солилцоог бүрэн цахимжуулах,

09

АЛБАН ХААГЧДЫН СУУРЬ ЧАДАМЖИЙН СТАНДАРТ БОЛОВСРУУЛАХ

Төрийн албан хаагчдын МХХТ-ийн суурь чадамжийн стандартыг боловсруулан, мөрдөх, тэдний ажлын гүйцэтгэлийн үнэлгээтэй уялдуулах

10

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦААСАН БОЛОН ЦАХИМ ХЭЛБЭРИЙН ДАВХАРДЛЫГ ХАЛАХ

Бүх түвшний байгууллагууд хоорондоо мэдээлэл солилцох болон иргэдэд үйлчилгээ үзүүлэхдээ цаасан болон цахим хэлбэрийн давхардлыг халж нэг ойлголтоор үйл ажиллагаагаа явуулах, үүний тулд зарим шаардлагатай эрх зүйн баримт бичгүүд, мөрдөж буй журмуудыг шинэчлэх,



Mongolian Marketing Consulting Group

YOUR RESEARCH PARTNER



АНХААРАЛ
ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА

